

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Автотээврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр хэрэгжихтэй холбоотойгоор “Улс хооронд байнгын ачаа тээврийн зөвшөөрлийн бичиг олгох, тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбоотойгоор “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолын 5 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт тус тус даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

УЛС ХООРОНД БАЙНГЫН АЧАА ТЭЭВРИЙН ЗӨВШӨӨРЛИЙН БИЧИГ ОЛГОХ, ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээрт заасан улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх автомашины “С” төрлийн зорчих зөвшөөрлийн бичиг /цаашид “зөвшөөрлийн бичиг” гэх/ олгох, тээвэрлэлтэд оролцогч байгууллагууд мэдээлэл солилцох, зөвшөөрлийн бичгийн ашиглалтад хяналт тавих үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмын зорилго нь зөвшөөрлийн бичиг олгох үйл ажиллагааг ил тод, шударга болгож, тээвэрчид уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцох тэгш боломжийг бүрдүүлэх, тээвэрлэлтийн хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

1.3. Улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч, зөвшөөрлийн бичиг олгох, ашиглах, хяналт тавих үүрэгтэй эрх бүхий албан тушаалтан, хуулийн этгээд болон хууль тогтоомжид заасан бусад байгууллага энэ журмыг мөрдөнө.

1.4. Энэ журам нь уул уурхайн бүтээгдэхүүнээс бусад импортын бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт гүйцэтгэх автомашинд зөвшөөрлийн бичиг олгох үйл ажиллагаанд хамаарахгүй.

Хоёр. Зөвшөөрлийн бичиг олгох үйл ажиллагаа

2.1. Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт гүйцэтгэх тээвэрлэгч нарт зөвшөөрлийн бичиг олгох үйл ажиллагааг олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн зохион байгуулна.

2.2. Зөвшөөрлийн бичиг олгох үйл ажиллагааг аливаа этгээдэд давуу байдал олгохгүйгээр ил тод, нээлттэй байдлаар зохион байгуулж, мэдээллийг олон нийтэд нээлттэйгээр хүргэж ажиллана.

2.3. Зөвшөөрлийн бичиг олгохдоо дараах зүйлийг харгалзан үзнэ. Үүнд:

2.3.1. Тээврийн үйл ажиллагаанаас олсон орлогыг үнэн зөв мэдүүлж, албан татвар төлсөн байдал;

2.3.2. Жолооч, ажилчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Хөдөлмөрийн хуульд заасан үүргээ хэрэгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;

2.3.3. Ачаа тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэл болон жолоочийг амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулсан байдал;

2.3.4. Үйлдвэрчний эвлэлийн гурван талт хэлэлцээрт заасан ажил олгогчийн зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн байдал;

2.3.5. Жолоочийн цалинтай уялдуулан нийгмийн даатгал төлсөн байдал;

2.3.6. Холбогдох стандартын шаардлагуудыг хангасан байдлын үнэлгээ.

2.4. Олон улсын автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохиролцогч нөгөө талаас олгосон нийт зөвшөөрлийн бичгийн 80 хүртэлх хувийг өмнөх жилийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор нэгдсэн мэдээллийн санд бүртгэгдсэн, хүсэлт илгээсэн бүх тээврийн хэрэгсэлд олгоно.

2.5. Биржээр худалдсан ашигт малтмалын тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэлд олгох зөвшөөрлийн бичгийг олборлолтын үйл ажиллагаа эрхлэгч нартай байгуулсан гэрээний дагуу тээвэрлэгчид олгох, эсхүл тухайн аж ахуйн нэгжид шилжүүлж болно.

2.6. Зөвшөөрлийн бичиг авсан тээвэрлэгч нь өөрийн компанийн тээврийн хэрэгсэлд олгосон зөвшөөрлийн бичгийг ашиглаж эхлэх хугацааг нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлснээр зөвшөөрлийн бичгийн хугацаа үйлчлэх хугацаа эхэлнэ.

2.7. Олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу зөвшөөрлийн бичгийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглох бөгөөд зөвшөөрлийн бичиг олгогдсон тээврийн хэрэгслийг өөр этгээдэд худалдан борлуулах тохиолдолд тухай тээврийн хэрэгсэлд олгосон зөвшөөрлийн бичиг хүчингүй болно.

2.8. Хэрэв зөвшөөрлийн бичгийн нөөц үлдэх тохиолдолд нэгдсэн мэдээллийн санд бүртгэлтэй тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд хувь тэнцүүлэн олгох, эсхүл энэ журмын 2.3-т заасан шаардлагыг харгалзан олгоно.

2.9. Тээврийн нэгдсэн мэдээллийн санд бүртгэх тээврийн хэрэгслийн тооны дээд хэмжээг тогтоох, хэмжээг өөрчлөх асуудлыг төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн хэвшил, олборлолтын үйл ажиллагаа эрхлэгч нарын төлөөллийг оролцуулсан орон тооны бус зөвлөлийг үйлдвэрийн газрын захирлын тушаалаар байгуулан шийдвэрлэж болно.

Гурав. Оролцогч байгууллагуудын эрх, үүрэг

3.1. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ /цаашид “үйлдвэрийн газар” гэх/ нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1.1. Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтэд оролцох аж ахуйн нэгж, тээврийн хэрэгсэл, жолоочийн нэгдсэн мэдээллийн санг хөтлөх, уг сангийн аюулгүй байдал, хөгжүүлэлтийг хариуцах;

3.1.2. Ачаа тээвэрлэлтэд ажиллах тээврийн хэрэгслийн техникийн байдлыг шалгах, 6 сар тутам бүртгэлтэй тээврийн хэрэгслийн үзлэг тооллогыг зохион байгуулж, мэдээллийн сан дахь мэдээллийг тогтмол шинэчлэх;

3.1.3. Экспортын ачаа урсгалын хэмжээ, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадалтай уялдуулан тээврийн хэрэгслийн бүртгэлийг зохион байгуулах, тухайн жилд ашиглах зөвшөөрлийн бичгийг хилийн боомтуудаар хуваарилах;

3.1.4. Тээвэрлэгч аж ахуйн нэгж, тээврийн хэрэгслийг мэдээллийн нэгдсэн санд бүртгэхдээ тээвэрлэлт хийх хилийн боомт, аж ахуйн нэгжийн тохирох ангилал, хөрөнгө оруулалтын хэлбэр тус бүрээр ангилан бүртгэх;

3.1.5. Зөвшөөрлийн бичиг эзэмшигч тээвэрлэгч аж ахуйн нэгжтэй хариуцлагын гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх;

3.1.6. Зөвшөөрлийн бичгийн олголтын талаарх мэдээ, тайланг олон нийтэд ил тод мэдээлэх;

3.1.7. Биржийн арилжаагаар худалдсан ашигт малтмалын тээвэрлэлтийг гүйцэтгэхэд шаардагдах зөвшөөрлийн бичгийг олборлолтын үйл ажиллагаа эрхлэгчээс ирүүлсэн хүсэлтийн дагуу шилжүүлэн өгөх, эсхүл тээвэрлэгчид олгох;

3.1.8. Зөвшөөрлийн бичиг олгох үйл ажиллагаа, улс хоорондын ачаа тээврийн зохицуулалт, зохион байгуулалттай холбоотой асуудлаар холбогдох байгууллагуудад санал хүргүүлэх;

3.1.9. Нэгдсэн мэдээллийн санд бүртгэх тээврийн хэрэгслийн тоог тухайн жилд олгох зөвшөөрлийн бичгийн тооноос хэтрүүлэхгүйгээр бүртгэх бөгөөд энэ журмын 3.1.2-т заасан үзлэг тооллогыг зохион байгуулахдаа холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулж болно.

3.2. Олборлолтын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1. Уурхай дотор болон гаалийн хяналтын талбайд хийгдэх ашигт малтмалын бүтээгдэхүүний ачилт, буулгалтын үеийн аюулгүй ажиллагааны дүрмийг баталж мөрдүүлэх;

3.2.2. Ашигт малтмалын бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээгээр тээвэрлэлтийг худалдан авагч тал хариуцах тохиолдолд тээвэрлэлтийн хөлсийг худалдан авагч талаас авч тээвэрлэгч нарт олгох;

3.2.3. Ашигт малтмалын бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээнд тээвэрлэлтийн үнэ, тарифыг Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан жишиг тарифаас багагүй байхаар тогтоох зохицуулалтыг тусгаж, хэрэгжүүлэх;

3.2.4. Тээвэрлэлтийн гэрээний үүргээ удаа дараа зөрчсөн тээвэрлэгч аж ахуйн нэгж, жолоочийг нэгдсэн мэдээллийн сангаас хасуулах, тээвэрлэлтэд оролцуулахгүй байх саналыг үйлдвэрийн газарт хүргүүлэх;

3.2.5. Тээвэрлэлтийг аль болох үндэсний хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлж, дотоодын тээвэрлэгч нарыг дэмжиж ажиллах бодлого баримтлах;

3.2.6. Экспортын төлөвлөгөө, тээвэрлэх ачааны хэмжээний талаарх мэдээллийг үйлдвэрийн газарт хүргүүлж, тээврийн хэрэгслийн тоог зөв зохистой хэмжээнд байлгах чиглэлээр үйлдвэрийн газартай хамтран ажиллах.

3.3. Тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.3.1. Үйлдвэрийн газрын нэгдсэн мэдээллийн санд тээврийн хэрэгсэл шинээр бүртгүүлэх, эсхүл хасах хүсэлт гаргаж, шийдвэрлүүлэх;

3.3.2. Жолоочтой байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн цалин хөлсийг олгох, хуульд заасны дагуу жолооч нарын эрүүл мэнд, нийгмийн даатгалыг авч буй цалинтай уялдуулан төлөх, жил бүр эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах;

3.3.3. Тусгай зориулалтын авто замаар хүнд даацын тээвэрлэлт гүйцэтгэх жолооч нарыг эрүүл мэнд, амь насны даатгалд хамруулах;

3.3.4. Өөрийн компанийн тээврийн хэрэгслийн техникийн байдлыг хангах, шаардлага хангахгүй, эсхүл өөр аж ахуйн нэгжид шилжүүлсэн тээврийн хэрэгслийн мэдээллийг үйлдвэрийн газарт хүргүүлж, бүртгэлээс хасуулах;

3.3.5. Тээврийн хэрэгсэлд олгосон зөвшөөрлийн бичгийг ашиглаж эхлэх тохиолдолд үйлдвэрийн газарт мэдэгдэж, нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлэх;

Дөрөв. Бусад зүйл

4.1. Дараах тохиолдолд тээвэрлэгчид зөвшөөрлийн бичиг олгохгүй. Үүнд:

4.1.1. Давагдашгүй хүчин зүйлээс бусад тохиолдолд гэрээний үүргээ удаа дараа биелүүлээгүй;

4.1.2. Хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, зөвшөөрлийн бичиг ашиглахтай холбоотой жолооч тээвэрчдээс аль нэмэлт төлбөр авсан нь тогтоогдсон;

4.2. Хил гаалиар хориотой бараа бүтээгдэхүүн тээвэрлэсэн, тээвэрлэхийг оролдсон, удаа дараа замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн, жолоодох эрхийн оноо дууссан жолоочийн хар жагсаалтыг үүсгэж болно;

Зөвшөөрлийн бичиг олгох схем, дараалал

№	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Үйл ажиллагаа	ТХ-ийн үзлэг тооллого зохион байгуулна	ТХ-ийг боомт тус бүрээр ангилан бүртгэнэ	Бүртгэгдсэн тээврийн хэрэгсэлд зөвшөөрлийн бичиг олгоно	ААН-үүд олгогдсон зөвшөөрлийн бичгийн хүрээнд төлөвлөлтөө хийнэ	Эхний ээлжид тээвэрлэлт гүйцэтгэх ТХ-ийн мэдээллийн АТҮТ-д илгээнэ	Зөвшөөрлийн бичгийн хүчинтэй хугацаа эхэлсэн ТХ-ийн мэдээллийн уурхай болон БНХАУ-ын талд мэдэгдэх	Биржээр худалдсан нүүрсийг тээвэрлэх зөвшөөрлийн бичгийг уурхайн хүсэлтээр шилжүүлэх, эсхүл тээвэрчдэд олгох	Зөвшөөрлийн бичгийн олголт, ашиглалтын мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх	Зөвшөөрлийн бичиг олгогдоогүй илүү гарсан тохиолдолд хэрхэн олгох талаар шийдвэр гаргаж, олон нийтэд мэдэгдэх
2	Хариуцах эзэх	АТҮТ ТББ, тээвэрчдийн төлөөлөл	АТҮТ		Тээвэрлэгч нар		АТҮТ			АТҮТ Орон тооны бус зөвлөл
3	Хугацаа	2-р улиралд	12.01-ний дотор	12.15-ны дотор	12.15-ны өдрийн дотор	12.20-ны дотор	12.25-ны дотор	Тухай бүр нь	Байнга	06.01-ний дотор
4	Тайлбар	Хийх бүртгэлийг бодит болгох	ТХ-ийн тоог 25000-аас хэтрүүлэхгүй байвал зохино.		8350-аас хэтрүүлэхгүй байвал зохино.			-	-	-